



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Спорт заалны журмыг шинэчлэн  
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Дүүргийн засаг даргын 2025 оны А/213 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын хорооны Спорт заалны журмыг нэгдүгээр хавсралтаар, заал түрээслүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шинэчлэн баталсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллуулахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Биеийн тамир, спортын хорооны даргын 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/77 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Р.ОЧИРПҮРЭВ

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын  
хорооны даргын 2025 оны 08 дугаар сарын  
13-ны өдрийн ..... дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ СПОРТ ЗААЛНЫ ЖУРАМ

- 1.Спорт Зааланд тоглож байгаа тамирчид, дасгалжуулагч, үйлчлүүлж буй иргэд нь хувцас солих өрөөнд хувцасаа сольж байх.
- 2.Спорт заалаар үйлчлүүлж буй иргэд тэмцээн үзэхээр ирсэн үзэгчид нь гадуур хувцасаа өлгүүрт өлгүүлж, улавчтай спорт зааланд орно.
- 3.Зориулалтын Биеийн тамирын хувцас болон кет пүүзтэй зааланд үйлчлүүлж байх.
- 4.Спорт Зааланд үйлчлүүлж буй иргэд нь заал зохион байгуулагч, багш дасгалжуулагч болон жижүүр, үйлчлэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэх.
- 5.Спорт зааланд үйлчлүүлж буй иргэд нь заалны эд хогшлыг эвдэж гэмтдэх, зааланд тамхи татах, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглоно.
- 6.Үйлчлүүлэгч нь хувийн эд зүйлсээ болон хамт ирсэн бага насны хүүхдийнхээ аюулгүй байдлыг өөрөө бүрэн хариуцна.

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ СПОРТ ЗААЛ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт заалыг болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, түрээслүүлэх, түрээстэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Чингэлтэй дүүргийн Биеийн тамир спортын хорооны баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэл, зорилготой уялдуулан заал ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.3 Түрээслэгч нь заал танхимыг ашиглах талаархи тодорхой мэдээллийг Биеийн тамир, спортын хорооны захиргаа, санхүүгийн албанд 1-3 /гурав/-аас доошгүй сарын өмнө урьдчилан мэдэгдэж, график төлөвлөгөөнд тусгуулан гэрээ байгуулж, зохих тарифын дагуу төлбөрийг хийнэ.
- 1.4 Түрээслэгч талын хүсэлтийг албан бичгээр болон амаар хүлээн авч, заал ашиглалтын төлөвлөгөөнд тусгаж, гэрээ байгуулна.
- 1.5 Заал ашиглахтай холбогдсон өдөр тутмын үйл ажиллагааг Биеийн тамир, спортын хорооны заал зохион байгуулагч зохион байгуулах үүрэгтэй бөгөөд Биеийн тамир, спортын хорооны дарга, спортын үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний өмнө хариуцлага хүлээнэ.
- 1.6 Заал ашиглах түрээсийн гэрээ байгуулах, төлбөр тооцооны гүйцэтгэл болон журмын хэрэгжилтэд Биеийн тамир, спортын хорооны зохион байгуулагч, нягтлан бодогч нар хяналт тавьж Биеийн тамир, спортын хорооны даргад танилцуулж байна.

### Хоёр. Заалны цаг ашиглалт, дотоод журам

- 2.1 Зааланд зохиогдох аливаа арга хэмжээний үргэлжлэх хугацаа 5 /тав / цаг хүртэл бол цагийн, түүнээс дээш хугацааг бүтэн өдрийн тарифаар тооцох ба оройн 20.00 цагаас хойш илүү цагийн төлбөр авна.
- 2.2 Заалыг гэрээнд заасан нөхцөл зориулалтын дагуу ашиглах бөгөөд байгууллагын болон заалны эд хогшлийг эвдэлж гэмтлэх, зааланд тамхи татах, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, ёс бус авир гаргах, зориулалтын бус хувцастай тоглох болон бэлтгэл сургуулилт хийхийг хатуу хориглоно.
- 2.3 Спорт заалыг түрээсэлсэн байгууллагын ажилтан, албан хаагчид, тамирчид эвдрэл гэмтэл гаргавал тухайн түрээсэлсэн байгууллага бүрэн хариуцаж эвдрэл гэмтлийг засаж хохиролгүй болгоно.
- 2.4 Амралтын өдөр түрээсэлж байгаа тохиолдолд заал ашиглахтай холбоотойгоор ажиллуулах үйлчилгээний ажиллагсдын илүү цагийн хөлсийг тооцон түрээсийн төлбөр дээр нэмж авна.
- 2.5 Тэмцээний удирдамж, шүүгчдийн бүрэлдэхүүн, спортын хэрэгсэл, материал хангамжтай холбогдсон асуудлыг түрээслэгч өөрөө шийдвэрлэх бөгөөд гадна

- талбай болон заал танхимд тавигдах реклам сурталчилгааны материалыг түрээслүүлэгч талтай тохиролцсоны үндсэн дээр байрлуулах буюу заалны зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.
- 2.6 Түрээслэгч талд шаардлагатай эд зүйлс, заал танхимыг тэмцээн эхлэх цагаас 30-60 минутын өмнө бэлэн болгоно.
- 2.7 Түрээсийн гэрээ байгуулсан боловч арга хэмжээ зохиогдохоос 3 хоногийн өмнө төлбөр тооцоогоо хийгээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгон цуцалж болно.

### **Гурав. Төлбөр тооцоо**

- 3.1 Цагийн хөлс нь 150,000 /зуун тавин мянга/ төгрөг, нэг өдрийн түрээсийн төлбөр 1,500,000 /нэг сая таван зуу/ төгрөг байна.
- 3.2 Дээд шатны байгууллага / Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо, Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар/ -ын хүсэлтээр спортын топ төрлүүд болох Монгол улсын үндэсний шигшээ баг байгуулсан төрлүүдээр насанд хүрэгчид, өсвөр, залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн болон Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болоон төрийн албан хаагчдын тэмцээнийг спорт зааланд үнэ төлбөргүй явуулж болно.
- 3.3 Хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдийн төлөөх олон нийтийн байгууллага, нийгмийн төлөөх тусгай спортын арга хэмжээ зохиогдох тохиолдолд БТСХорооны даргын зөвшөөрөлтэйгээр үнэ төлбөргүй болон 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй тарифаар ашиглуулж болно.



Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын  
хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын  
13 -ны өдрийн 1167 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

1115104453 9114637

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ УСАН БАССЕЙНД МӨРДӨХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Усан бассейнд бэлтгэл хийх нийт үйлчлүүлэгч, суралцагч тамирчид, дасгалжуулагч нар нь Спорт хороонд мөрдөх журам, үйлчлүүлэгч нарт тавих шаардлагыг хэрэгжүүлж, энэхүү журмыг баримтална.

1.2 Усан бассейн Даваа гаригт дотоод ажилтай тул амарч бусад өдрүүдэд өглөө 07 цагаас орой 20 цаг хүртэл ажиллана.

### Хоёр.Тавигдах шаардлага

2.1 Бассейнд ороход дараах хувцас, хэрэгсэлтэй ирсэн байна.

- Нүдний шил
- Усны малгай Плавка, купальник
- Зориулалтын тавчиг
- Бие арчих алчуур
- Бие угаагч
- Саван, шампунь

/дээрх зүйлсийг авч ирээгүй тохиолдолд бассейнд үйлчлүүлэхгүй/

2.2 Доорх шинжилгээнд хамрагдана.Үүнд:

Том хүн - RPR, МАЗОК

Хүүхэд - Цагаан хорхой

### Гурав. Үйлчлүүлэгч, хичээллэгчдийн үүрэг

3.1 Хичээл эхлэхээс 15 минутын өмнө ирсэн байх ба гадуур гутлаа хүлээлгийн хэсэгт сольж шаахайгаа өмсөөд, угтах үйлчилгээний картаа уншуулж нэвтэрч орно.

3.2 Төлөвлөгөөнд тусгагдсан сургалт дасгалжуулалтад идэвхтэй хамрагдах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бэлтгэл таслахгүй байх, дасгалжуулагч багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх мөн тамирчны ёс зүй, сахилга батын алдаа гаргахгүй байх

3.3 Бэлтгэлийн цагийн хуваарийн дагуу орж, гарах цаг баримтлах, бэлтгэл эхлэхээс 15 минутын өмнө хувцсаа сольж шүршүүрт орсон байх. Бэлтгэл хийхэд шаардлагатай бусад хувийн бэлтгэлийг хангасан байх.

3.4 Бассейны картыг бусдад дамжуулахыг хориглох ба дамжуулсан тохиолдолд картыг хураан авна.

3.5 Хичээллэгчид 12 удаагийн оролттой сургалтад хамрагдах бөгөөд тухайн сардаа сургалтаа дуусгана.

Хүндэтгэн үзэх шалтгаан гарсан үед усан бассейны багш, угтах үйлчилгээний ажилтанд заавал мэдэгдэж, картан дээр тэмдэглүүлэн хичээлийг түр хаалгана. Хаалгасан хичээлийг нөхөн орно. Үүнд: Гадаад, дотоодод томилолтоор явсан, эмэгтэйчүүдийн шалтгаантай, удаан хугацааны өвчтэй байсан тохиолдолд эмнэлгийн магадалгааг харгалзан үзнэ.

3.6 Усан бассейн, душны өрөөний ариун цэврийг дээд зэргээр сахих, хог хаяхгүй байх, Энэхүү журмыг биелэлтэд нь дасгалжуулагч, эрүүл ахуйч, аврагч нар

хяналт тавьж ажиллана.

3.7 Усан бассейн, душны өрөөний эд зүйлсийг ариг гамтай ашиглах, эвдэж гэмтээхгүй байх, дасгалжуулагч, аврагч нар болон жижүүр, үйлчлэгч нарын тавьсан шаардлагыг биелүүлэх. Эд зүйлсийг эвдэж гэмтээсэн бол гарсан хохирлыг тухайн хүн бүрэн хариуцаж барагдуулна.

3.8 Усан бассейны бүх хэсэгт архи, тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис болон хөзөр, мөрийтэй тоглоом тоглохыг хатуу хориглоно.

**Дөрөв: Усан бассейны төлбөр**

Усан бассейнд үйлчлүүлэхдээ төрийн санд төлбөрөө төлнө.

Том хүн- 12,000 төгрөг

Хүүхэд – 10,000 төгрөг

Чөлөөт сэлэлт – 1 сарын 120,000 (том хүн)

1 сарын 100,000 (хүүхэд)

**Тав. Бассейнд ороход хориглох зүйлс**

3.1 Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ бассейнд орох

3.2 Биеийн даралт хэвийн бус үед бассейнд орох

3.3 Бие тавгүйрсэн буюу хэт ядарсан үед бассейнд орох

3.4 Ил шархтай буюу халдварт өвчинтэй хүн бассейнд орох

3.5 Багшийн зөвшөөрөлгүйгээр бассейн руу орох, гарах

3.6 Бассейны шатгүй хэсгээс үсрэх, усны гүн рүү шумбах, усан дотор ноцолдох, бие биенийгээ ус руу түлхэх гэх мэт

3.7 Амандаа бохитой буюу юм амандаа идэх зүйлтэй бассейнд орохыг хориглоно

3.8 Чанга дуугаар хашгирч орилох бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах

3.9 Душ болон бассейн дотор гүйж, харайх

3.10 0-6 наснаас доош насны хүүхдүүдийг харгалзах хүнгүйгээр оруулах.

**Зургаа. Бусад зүйл**

5.1 Бассейны журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд хичээллэгчдийн суралцах эрхийг захиргаанаас хасаж төлбөрийг буцаан олгохгүй.

5.2 Байгууллагын үйлчилгээ болон сургалтын талаар санал гомдлыг байгууллагын захиргаанд өөрийн биеэр болон бичгээр мэдэгдэн

5.3 Энэ журам нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа бүх хүмүүст хамаарагдана.

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын  
хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын  
13-ны өдрийн 13/07 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1115104453 ☎ 9114637

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ МӨСӨН ХОККЕЙН МӨРДӨХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Мөсөн гулгуурын талбайд хоккей, тэшүүрийн төрлүүдийн бэлтгэл сургуулилт нийтийн гулгалтад үйлчлүүлэх нийт үйлчлүүлэгч, суралцагч тамирчид, дасгалжуулагч нар нь Спорт хороонд мөрдөх журам, үйлчлүүлэгч нарт тавих шаардлагыг хэрэгжүүлж, энэхүү журмыг баримтална.

1.2. Мөсөн гулгуурын талбай нь өдөр бүр өглөө 08 цагаас орой 21 цаг хүртэл ажиллана.

### Хоёр. Тавигдах шаардлага

**2. Үйлчлүүлэгч нь мөсөн гулгуурын талбайгаар үйлчлүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна.**

- 2.1 6-аас дээш настай
- 2.2 Анхлан суралцагч нь зориулалтын тэшүүртэй, тусгай талбайд гулгана.
- 2.3 Үйлчлүүлэгч нь мөсөн гулгуурын талбай дээр гарахдаа заавал хамгаалалтын хэрэгслийг бүрэн зориулалтын дагуу өмссөн байна.
- 2.4 Үйлчлүүлэгч нь талбай дээр гулгах аюулгүй ажиллагааны зааварчилгаатай заавал танилцаж гарын үсэг зурсан байна.
- 2.5 Анхлан гулгагч нь анх гулгаж байгаагаа мөсөн гулгуурын ажилтанд заавал мэдэгдэж анхан шатны гулгах техникийн зааварчилгаа авсан байна.
- 2.6 Зүрх судасны өвчтэй болон жирэмсэн эхчүүд гулгахыг хориглоно.
- 2.7 Мөсөн гулгуурын талбай бүх хэсэгт архи согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис болон хөзөр мөрийтэй тоглоом тоглохыг хатуу хориглоно.
- 2.8 Хэт хурдтайгаар гулгахгүй, огцом эргэлт, зогсолт хийх, хоорондоо уралдахгүй гинжин цуваа үүсгэж гулгахгүй байх
- 2.9 Мөсөн гулгуурын талбайд кассаас олгосон аюулгүйн тоноглол, хэрэгслүүдээс бусад хувийн тоноглол, хэрэгсэл болон тоглоомыг мөсөн гулгуурын талбайд авч орохыг хориглоно.
- 2.10 Гулгаж байх явцад чихэвч зүүх, утсаа оролдох, зураг дарахаар хэт удаан зогсох, бусдад саад учруулахыг хориглоно.
- 2.11 Гулгаж байх явцдаа бусад үйлчлүүлэгчийг мөргөх, түлхэх, шүргэх, татах зэрэг үйлдлүүдийг хориглоно.
- 2.12 Үйлчлүүлэгч нь өөрийн гулгах чадвараас хамаарч зөвхөн өөрийн харьяалагдах бүсэд, сумны дагуу нэгэн чигт гулгана.
- 2.13 Мөсөн гулгуурын талбай руу идэх болон уух зүйлстэй орохыг хориглоно.
- 2.14 Гулгахдаа үйлчлүүлэгч нь урд гулгаж байгаа үйлчлүүлэгчээс хамгийн багадаа 1,5м зай барьж өөрийн аюулгүй байдлыг хангаж гулгана.
- 2.15 Үйлчлүүлэгч нь унахдаа гараа хагас атган унах
- 2.16 Мөсөн гулгуурын талбай дээр гулгахдаа хамгаалалтын порт болон акрилл хаалтуудыг мөргөх, цохих, түлхэх зэргээс сэргийлж өөрийн аюулгүй байдлыг хангах.
- 2.17 Мөсөн гулгуурын талбай дээр бага насны хүүхэдтэй гулгаж байх хугацаандаа талбайн зориулалтын бүсэд, анхаарал болгоомжтой, удаанаар, эргэн



тойрны үйлчлүүлэгчдээс хамгийн багадаа 2м зайтай гулган Үйлчлүүлэгч нь талбай дээр гулгаж байх хугацаанд мөсөн гулгуурын ажилтны заавар, зөвлөмжийг зааврыг биелүүлнэ.

2.18 Мөсөн гулгуурын ажилтан албан хаагчид иргэдтэй зөв боловсон ёс зүйн өндөр түвшинд харилцаж аюулгүй байдлыг ханган ажиллана.

2.19 Багш дасгалжуулагчид батлагдсан хуваарийн дагуу бэлтгэл сургуулилтыг хийлгэж багшийн ёс зүйг баримтлан ажиллах.

**Гурав: Төлбөр**

- Том хүн: Чөлөөт гулгалт- 1 цаг 10,000 төгрөг
- Хүүхэд: Чөлөөт гулгалт -1 цаг 5,000 төгрөг
- Мөсөн талбайн 1 цагийн төлбөр 300,000 төгрөг
- Төлбөрийн төрийн сангийн дансанд хийнэ.

**Дөрөв: онцгой байдлын үед авах арга хэмжээ**

3.1 Орох, гарах гарц чөлөөтэй байлгах

3.2 Галын дохиолол дуугарсан үед тэшүүр тайлалгүй, буцаан өгөлгүйгээр аваарын гарцаар гарч барилгын зүүн талд байрлах

ЦУГЛАХ ЦЭГ-т цугларна.

**Бусад зүйл**

4.1 Мөсөн гулгуурын талбайд журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд хичээллэгчдийн суралцах эрхийг захиргаанаас хасаж төлбөрийг буцаан олгохгүй.

4.2 Байгууллагын үйлчилгээ болон сургалтын талаар санал гомдлыг байгууллагын захиргаанд өөрийн биеэр болон бичгээр мэдэгдэнэ.

4.3 Энэ журам нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа бүх хүмүүст хамаарагдана.

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын  
хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын  
13 -ны өдрийн 1107 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

1115104453 9114637

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ФИТНЕСИЙН ЗААЛАНД МӨРДӨХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Чийрэгжүүлэх танхимаар үйлчлүүлж байгаа нийт үйлчлүүлэгч нар Спорт цогцолбор дотор мөрдөх журам, үйлчлүүлэгчдэд тавигдах шаардлагыг хэрэгжүүлж, энэхүү журмыг баримтална.

1.2 Фитнесийн заал өглөө 07 цагаас орой 20 цаг хүртэл ажиллаж Бүтэн сайнд амарна.

### Хоёр. Тавигдах шаардлага

2.1 Чийрэгжүүлэх танхимаар үйлчлүүлэхдээ гадуур хувцсаа өлгүүрт өлгүүлж, зориулалтын пүүз өмсөж орох

2.2 Үйлчлүүлэгч нар дараах хувцас, хэрэгсэл материалтай ирсэн байна.

- Сольж өмсөх хувцас
- Усанд орох алчуур саван зориулалтын тавчик
- Эмчийн үзлэгт харагдсан байх.

2.3 Фитнес заал болон хувцас солих өрөөнд ариун цэврийг дээд зэргээр сахих.

### Гурав. Аюулгүй байдлыг хангах

3.1 Чийрэгжүүлэх танхимд багшийн зааврын дагуу хичээллэх.

3.2 Чийрэгжүүлэх танхимын тоног төхөөрөмжийг багшийн зааврын дагуу ашиглах.

3.3 Хэрэглэсэн гантель, бусад тоног төхөөрөмж, дискээ хураах.

3.4 Душ болон хувцас солих өрөөнд гүйж харайх, ноцолдохгүй байх.

### Дөрөв. Ослоос урьдчилан сэргийлэх

4.1 Хэт хүнд жингээр дасгал хийхгүй байх.

4.2 Бусад хичээллэгчдийн дасгал хийж байхад саад болохгүй байх.

4.3 Гүйлтийн зам, бусад тоног төхөөрөмж дээр анхаарал болгоомжтой байх.

4.4 Дасгал хийхээс өмнө бие халаалтын дасгалыг бүрэн хийсэн байх.

4.5 Цаг болон гинж бөгжтэй дасгал хийхгүй байх.

4.6 Чанга дуугаар орилж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх.

4.7 Фитнес зааланд хараалын үг хэллэг хэрэглэхгүй байх

### Тав. Дараах үйлчлүүлэгчийг орохыг хориглоно.

5.1 Жирэмсэн

5.2 16 наснаас доош бага насны хүүхэд

5.3 Төлбөр төлөөгүй болон зөвшөөрөл аваагүй

5.4 Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үед

5.5 Ил шархтай болон халдварт өвчтэй хүн

5.6 Гадуур хувцастай дасгал хийх

5.7 Биеийн даралт хэвийн бус үед

5.8 Бие тавгүй буюу хэт ядарсан үед фитнес зааланд орохыг хориглоно.

**Зургаа. Фитнест орохдоо дээрх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд цаашид хичээллэх эрхийг хасна.**

6.1 Фитнесийн талбайд архи согтууруулах ундаа хэрэглэх.

6.2 Үйлчлүүлэгчийг гэмтээж бэртээх.

6.3 Бусдын эд хөрөнгийг зөвшөөрөлгүй авсан тохиолдолд.

**Долоо. Төлбөр тооцоо**

7.1 Том хүн 120,000 төгрөг

7.2 Хүүхэд 100,000 төгрөг

7.3 фитнес заалаар үйлчлүүлэгч 7 хоногоос их хугацаанд хөдөө орон нутаг, гадаад улс, болон хичээллэх боломжгүй бэртэл авсан тохиолдолд хугацааг нөхөн олгоно.

**Найм. Бусад зүйл.**

8.1 Байгууллагын үйлчилгээ болон сургалтын талаар санал гомдлыг байгууллагын захиргаанд өөрийн биеэр болон бичгээр мэдэгдэнэ.

8.2 фитнес заалны тоног төхөөрөмж эд зүйлсийг эвдсэн тохиолдолд нөхөж төлнө.

8.3 Энэхүү журам нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа бүх хүмүүст хамаарна.